



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 дугаар сарын 22

№ 01/47 ДУА-2018/15/ТА-ТШЗ Мандалговь хот

Зөрчлийг арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Адаацаг сумын Засаг даргын Тамгын газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх явцад үндсэн цалингийн зардлаас 174,000.00 /нэг зуун далан дөрвөн мянган/ төгрөгийн ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/, Сангийн сайдын 2014 оны 03 дугаар сарын 14-ний 55 дугаар тушаалын 6 дугаар хавсралтаар батлагдсан "Цалингийн сүлжээ болон бусад холбогдох эрх зүйн актын дагуу тогтоон олгож байгаа албан тушаалын үндсэн цалин энэ ангилалд багтана" заасныг тус тус зөрчсөн байна.



Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Төсвийг зориулалтын дагуу зарцуулах, дотоод хяналтыг сайжруулах

Албан шаардлагын биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг даргын Тамгын газрын төсвийн шууд захирагч Б.Уранцэцэг, нягтлан бодогч Б.Энхжаргал нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:
АУДИТОР  Ж.УГТАХБАЯР

ЗӨВШӨӨРСӨН:
ЗДТГ-ИЙН ДАРГА  Б.УРАНЦЭЦЭГ
НЯГТЛАН БОДОГЧ  Б.ЭНХЖАРГАЛ

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.